



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 447


Улаанбаатар хот


Удирдамж өгөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Сангийн яамны 2020 оны 8-3/6024 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинэ төрлийн “Корона вирус”-ийн халдварт өвчний тархалттай холбоотойгоор “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн олон улсын хуваарын нислэгүүд цуцлагдсанас шалтгаалж компанийд санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул цаашид компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор 35,000,000,000 /Гучин таван тэрбум/ төгрөг буюу 15,000,000 /Арван таван сая/ хүртэлх амдолларын эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу дотоодын арилжааны банктай боломжит нөхцөлөөр байгуулах эрх олгохыг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА 
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.БАЯР-ЭРДЭНЭ

900900